



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2018 оны 09 сарын 14 өдөр

Дугаар 118 ГАГ-БНАТАГ-12018/СС-ГА
Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу "2016, 2017 оны Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмийн зардлын төлөвлөлт, гүйцэтгэл, худалдан авалтын байдал"-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аймгийн Нэгдсэн эмнэлэг 900.9 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг тендерийн гэрээний үнээс илүү үнээр худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1.2-т заасан "Энэ хуулийн 40.4-т зааснаас бусад тохиолдолд гэрээний үнийг нэмэгдүүлэн өөрчлөхийг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т заасан "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь "...төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан" зөрчилд төрийн аудитын байгууллага төлбөрийн акт тогтооно гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

Нэг. Тендерийн гэрээний үнээс илүү төлсөн 900,900 /Есөн зуун мянга есөн зуун/ төгрөгийг хавсралтад заасан бэлтгэн нийлүүлэгч компаниудаар төлүүлж, аймгийн Төрийн сан дахь бусад татвар хураамжийн орлогын 10030000947 тоот дансанд төвлөрүүлэх.

2518117

Хоёр. Төлбөрийн актыг 2018 оны 10 дугаар сарын 25-ны дотор бүрэн барагдуулж, холбогдох санхүүгийн баримтыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга Н.Баттогтох, ерөнхий нягтлан бодогч Д.Сайнбаяр, эмийн нягтлан бодогч Д.Ганхүлэг нарт хариуцуулав.

АКТЫГ


ТОГТООСОН:

АУДИТОР Д.БАЗБАЯР
АУДИТОР Б.НАРАНГЭРЭЛ



ЗӨВШӨӨРСӨН:

БАЯНХОНГОР АЙМГИЙН НЭГДСЭН
ЭМНЭЛГИЙН ДАРГА
Н.БАТТОГТОХ
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ
Д.САЙНБАЯР
ЭМИЙН НЯГТЛАН БОДОГЧ
Д.ГАНХҮЛЭГ



1. Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын
газрын 2018 оны 09 дугаар сарын
14-ний өдрийн 118 тоот актын
хавсралт

6417143544
БҮОА0067 9007433

мянган төгрөг

дд	Бэлтгэн нийлүүлэгчийн нэр	Эмийн нэр төрөл	Гэрээний үнээс илүү авсан мөнгөн дүн		Нийт дүн
			2016 он	2017 он	
1	Бүрэн хайрхан сервис ХХК	6	352,1	156,1	508,2
2	Монгол фарм ХХК	4	20,0	159,0	179,0
3	Монос фарм трейд ХХК	9	69,6	108,1	177,7
4	Мөнхийн тун ХХК	1		36,0	36,0
Нийт дүн		20	441,7	459,2	900,9

--- оОо ---



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2018 оны 09 сарын 14 өдөр

Дугаар 119 ГАГ-БНАТАГ-12018/-06-ГА Номгон

Г Төлбөр барагдуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу "2016, 2017 оны Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмийн зардлын төлөвлөлт, гүйцэтгэл, худалдан авалтын байдал"-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нэгдсэн эмнэлгийн эмийн сан нь 57285 төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг захиалгын хуудасгүйгээр олгож, захиалгын хуудсаар олгосон эмээс 86400 төгрөгөөр илүү дүнгээр зарлагадсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д заасан "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.7-д заасан "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ...", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь "...төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан" зөрчилд төрийн аудитын байгууллага төлбөрийн акт тогтооно гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

Нэг. Нягтлан бодох бүртгэлд анхан шатны баримтгүй бүртгэсэн 57,285 төгрөг, захиалгын хуудсаар олгосон эмээс илүү дүнгээр зарлагадсан 86,400 төгрөгийн нийт 143,685 /Нэг зуун дөчин гурван мянга зургаан зуун наян таван/ төгрөгийг холбогдох



2518119


ажилчдаар төлүүлж, Төрийн сан дахь бусад татвар хураамжийн орлогын 10030000947 тоот дансанд төвлөрүүлэх.

Хоёр. Төлбөрийн актыг 2018 оны 10 дугаар сарын 20-ны дотор бүрэн барагдуулж, холбогдох санхүүгийн баримтыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга Н.Баттогтох, ерөнхий нягтлан бодогч Д.Сайнбаяр, эмийн нягтлан бодогч Д.Ганхүлэг нарт хариуцуулав.

АКТЫГ

ТОГТООСОН:

АХЛАХ АУДИТОР  Б.ДОЛЖМАА
АУДИТОР  П.МӨНХ-ЭРДЭНЭ
АУДИТОР  Б.НАРАНГЭРЭЛ




ЗӨВШӨӨРСӨН:

БАЯНХОНГОР АЙМГИЙН НЭГДСЭН
ЭМНЭЛГИЙН ДАРГА  Н.БАТТОГТОХ
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ
 Д.САЙНБАЯР
ЭМИЙН НЯГТЛАН БОДОГЧ
 Д.ГАНХҮЛЭГ



1. Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын
газрын 2018 оны 09 дугаар сарын
14-ний өдрийн 149 тоот актын
хавсралт



дд	Тасаг , нэгжийн нэр	Захиалгын хуудасгүй зарлагадсан	Захиалгын хуудсаас илүү зарлагадсан	Нийт дүн
1	Амбулатори		44,0	44,0
2	Дотрын тасаг		41,6	41,6
3	Өдрийн эмчилгээ	16,8		16,8
4	Халдварт	24,6		24,6
5	Төрөх тасаг	16,6		16,6
	Нийт дүн	58	85,6	143,6

--- оОо ---